



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянзүрх дүүргийн АЧИТ ЧАГНУУР ӨЭМТ-ийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/176/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга: Г.Нандинжаргал Утас: 7000-7734 Цахим хаяг: nandinjargal.g@audit.gov.mn Санхүүгийн аудитын албаны ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 11315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 11315558 Цахим хаяг: altantsetseg.ya@audit.gov.mn Аав ээжийн тэнгэрлэг буян аудит ХХК-ийн захирал О.Бурмаа Утас: 99168735 Цахим хаяг: aetb.audit@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.13 № 762
танай _____-ны № _____-г

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ
ДҮҮРГИЙН АЧИТ ЧАГНУУР
ӨЭМТ-ИЙН ДАРГА У.БАДАМЦЭЦЭГ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Баянзүрх дүүргийн Ачит Чагнуур ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ гэсэн 4 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Ачит Чагнуур ӨЭМТ нь анхан шатны тусламж үйлчилгээний гүйцэтгэлд Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнд ногдох зардлын санхүүжилтээр 429.6 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, 19,901 иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Ачит Чагнуур ӨЭМТ-ийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар бүтэц орон тоог 18 байхаар баталж, тайлант онд 15 орон тоогоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Ачит чагнуур ӨЭМТ-ийн 2025 оны гурвалсан гэрээний биелэлт 92.9 хувь, ЭМДЕГ-тай байгуулсан эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах гэрээний биелэлт 97.9 хувийн хэрэгжилттэй гэж үнэлэгдсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	2,638,783.89	4,394,459.83
Дансны авлага	27,408,383.01	5,391,450.40
Бусад авлага		405,232.38
Бараа материал	15,396,333.88	23,346,264.01
Эргэлтийн хөрөнгийн дүн	45,443,500.78	33,537,406.62
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	84,618,62.87	81,223,703.14
Биет бус хөрөнгө	1,706,833.28	1,274,166.56
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	86,324,896.15	82,497,869.70
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	131,768,396.93	116,035,276.32
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Дансны өглөг	24,977,270.86	3,644,170.06
Татварын өглөг		7,160,292.87
НДШ-ийн өглөг	6,834,137.53	52,865.00
Богино хугацаат өр төлбөрийн дүн	31,811,408.39	10,857,327.93
Өр төлбөрийн нийт дүн	31,811,408.39	10,857,327.93
Эзэмшигчдийн өмч		
Хувийн	20,000.00	20,000.00
Хуримтлагдсан ашиг	99,936,988.54	105,157,948.39
Эзэмшигчдийн өмчийн дүн	99,956,988.54	105,177,948.39
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	131,768,396.93	116,035,276.32

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Нийт орлогын дүн	424,812,298.17	438,297,848.62
Санхүүжилтийн орлого	389,768,298.17	429,649,820.20
Бусад орлого	30,580,000.00	4,200,306.47
Туслах үйл ажиллагааны орлого	4,464,000.00	4,427,721.95
Нийт ашиг (алдагдал)	424,812,298.17	438,297,848.62
Хүүний орлого	53,632.51	103,388.60
Ерөнхий ба удирдлагын зардал	360,663,005.49	433,023,082.15
Санхүүгийн зардал		
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	64,202,925.19	5,378,155.07
Орлогын татварын зардал	5,363.27	10,338.86
Татварын дараах ашиг (алдагдал)	64,197,561.92	5,367,816.21
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	64,197,561.92	5,367,816.21
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	64,197,561.92	5,367,816.21

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	374,733,394.16	456,094,474.76
Татаас, санхүүжилтийн орлого	370,269,394.16	451,666,752.81
Туслах үйл ажиллагааны орлого	4,464,000.00	4,427,721.95
Бусад мөнгөн орлого		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	374,733,394.16	456,094,474.76
Мөнгөн зарлагын дүн	355,235,739.53	441,255,487.42
Ажиллагчдад төлсөн	214,152,872.83	247,687,297.79
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	57,197,092.42	83,968,123.47
Бараа материал худалдан авахад төлсөн	42,363,131.92	70,787,729.77
Ашиглалтын зардалд төлсөн	7,905,183.00	3,131,472.00
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,600,000.00	3,900,000.00
Татварын байгууллагад төлсөн	21,548,096.09	19,757,765.49
Бусад мөнгөн зарлага	8,469,363.27	12,023,098.90
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	355,235,739.53	441,255,487.42
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	19,497,654.63	14,838,987.34
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	57,832.51	103,388.60
Хүлээн авсан хүүний орлого	57,832.51	103,388.60
Мөнгөн зарлагын дүн	17,182,900.00	13,186,700.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	16,709,900.00	13,186,700.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	473,000.00	
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн	17,182,900.00	13,186,700.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(17,125,067.49)	(13,083,311.40)
Санхүүгийн мөнгөн гүйлгээний дүн		
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	2,372,587.14	1,755,675.94
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	266,196.75	2,638,783.89
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,638,783.89	4,394,459.83

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	20,000.00	-	-	-	-	27,825,747.62	27,845,747.62
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт		.				7,913,679.00	7,913,679.00
Залруулсан үлдэгдэл					-	35,739,426.62	35,739,426.62
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)						64,197,561.92	64,197,561.92
2024 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	20,000.00	-	-	-	-	99,936,988.54	99,956,988.54
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт						(146,856.36)	(146,856.36)
Залруулсан үлдэгдэл	20,000.00	-	-	-	-	99,790,132.18	99,810,132.18
Өмчид гарсан өөрчлөлт		.				-	-
Зарласан ногдол ашиг					-		-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)						5,367,816.21	5,367,816.21
2025 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	20,000.00	-	-	-	-	105,157,948.39	105,177,948.39

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 132,003.5 мянган төгрөгийн 6 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулга хийлгэж баталгаажуулсан. Үүнд:

- Санхүү байдлын тайланд татварын өглөгийг 93.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг;
- Санхүү байдлын тайланд нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг 52.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг;
- Тайланд хугацаанд үндсэн хөрөнгөд 682.0 мянган төгрөгийн элэгдлийг дутуу тооцсныг;
- Мөнгөн гүйлгээний тайланд нийгмийн даатгалын байгууллагад төлсөн 36,663.7 мянган төгрөгийн шимтгэлийн зардлыг ажилчдад төлсөн мөнгөн зардлын ангиллаар буруу тайлагнасныг;
- Цахим орлогын татварын тайланд 103.4 мянган төгрөгийн хүүгийн орлогыг тусгай хувь хэмжээгээр ноогдуулах татварын тооцоонд тусгаагүй байсныг;
- Цахим орлогын татварын тайланд орлогыг 44,256.6 мянган төгрөгөөр илүү, зардлыг 50,150.9 төгрөгөөр илүү, нийт 94,407.5 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасныг тус тус залруулав.

Энэ нь НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 “Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх” болон санхүүгийн тайлагналын “үнэлгээ ба хуваарилалт”, “ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар зөрчил² илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүү байдлын тайланд Татварын өглөгийг 93.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	93.9			1	93.9	1	93.9				
Санхүү байдлын тайланд Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг 52,9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	52.9			1	52.9		52.9				
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 682.0 мянган төгрөгөөр дутуу тооцож тайлагнасан.	1	682.0	1	682.0			1	682.0				
Мөнгөн гүйлгээний тайланд нийгмийн даатгалын байгууллагад төлсөн 36,663.7 мянган төгрөгийн шимтгэлийн зардлыг ажилчдад төлсөн мөнгөн зардлын ангилалаар буруу тайлагнасан байна.	1	36,663.7			1	36,663.7	1	36,663.7				
Цахим орлогын татварын тайланд 103.4 мянган төгрөгийн хүүгийн орлогыг Тусгай хувь хэмжээгээр ногдуулах татварын тооцоонд тусгаагүй байна.	1	103.4			1	103.4	1	103.4				
Цахим орлогын татварын тайланд орлогыг 44,256.6 мянган төгрөгөөр илүү, зардлыг 50,150.9 мянган төгрөгөөр илүү, нийт 94,407.5 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна.	1	94,407.5			1	94,407.5	1	94,407.5				
Дүн	6	132,003.5	1	682.0	5	131,321.5	6	132,003.5				